



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг
Утас: 70-56-21-12, Факс: 70-56-21-12
E-mail: khentii@audit.gov.mn

2024.07.30 № 696
танай _____ -ны № _____ -т

ХЭНТИЙ АЙМГИЙН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ЭЭЛЖИТ СОНГУУЛЬД ОРОЛЦОХ
БАТШИРЭЭТ СУМЫН АРДЧИЛСАН
НАМЫН ХОРООНД

Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд
заасан шаардлагад нийцсэн талаарх
дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд 2024 оны Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох Батширээт сумын Ардчилсан намын хорооны сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

2024 оны Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь 2024 оны Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Төрийн аудит. Тулгуур зарчим, MNS 6817-6:2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим, MNS 6817-8:2020 Төрийн аудит. Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол

232420723

Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

Дүгнэлт

Батширээт сумын Ардчилсан намын хорооны Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Батширээт сумын Ардчилсан намын хорооны мөрийн хөтөлбөр (15 хуудас)-ийг хавсаргав.

Хувийг: Батширээт сумын Сонгуулийн хороонд.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ж.ГАНБААТАР

ХЯНАСАН:
АУДИТЫН МЕНЕЖЕР


Д.ОЮУНТУЯА

БОЛОВСРУУЛСАН:
АУДИТОР

Ц.ХАТАНБОЛД

АУДИТОР


Т.АЛТАНШАГАЙ



**АЙМАГ, НИЙСЛЭЛ, СУМ, ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 2024 ОНЫ ЭЭЛЖИТ СОНГУУЛЬД
ХЭНТИЙ АЙМГИЙН БАТШИРЭЭТ СУМЫН АРДЧИЛСАН
НАМААС ДЭВШҮҮЛЖ БУЙ МӨРИЙН ХӨТӨЛБӨР**



**БАТШИРЭЭТ СУМ
БҮТЭН МОНГОЛ- БҮРЭН АРДЧИЛАЛ
ЭРЧИМТ ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**




2024 он

АГУУЛГА

ӨМНӨТГӨЛ	4
НЭГ. БҮТЭН МОНГОЛ	5
1.1 ХУВИАРАА ХӨДӨЛМӨР ЭРХЛЭГЧИД.....	5
1.2 ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРТ АЖИЛЛАГСАД: МАЛЧИД, ТАРИАЛАНЧИД БОЛОН БУСАД.....	5
1.3 ТӨРИЙН АЛБАН ХААГЧИД.....	5
1.4 СОЁЛ, УРЛАГ, СПОРТЫН САЛБАРЫН АЖИЛЛАГСАД.....	5
1.5 ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮН.....	5
1.6 СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН НАСНЫ ХҮҮХДҮҮД.....	6
1.7 ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН СУРАГЧИД.....	6
1.8 ОЮУТАН, ЗАЛУУЧУУД.....	6
1.9 ЗАЛУУ ГЭР БҮЛ ба ӨРХ ТОЛГОЙЛСОН ЭЦЭГ, ЭХ.....	6
1.10 АХМАДУУД.....	6
1.11 ГАДААДАД СУРЧ, АЖИЛЛАЖ, АМЬДАРЧ БАЙГАА ИРГЭД.....	6
1.12 ОРОН СУУЦ, ГЭР ХОРООЛОЛД АМЬДАРДАГ ИРГЭД.....	7
1.13 АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЛБАРТ АЖИЛЛАГСАД.....	7
ХОЁР. СЭРСЭН МОНГОЛ	7
2.1 ЦОГЦ БОЛОВСРОЛ.....	7
2.1.1 Боловсролын их шилжилт ба хүртээмж.....	7
2.1.2 Сургуулийн өмнөх боловсрол.....	7
2.1.3 Бага, дунд боловсрол.....	7
2.1.4 Багшийн мэргэжлийн хөгжил.....	8
2.2 ЭРҮҮЛ МЭНД – ЭРХЭМ БАЯЛАГ.....	8
2.2.1 Нийгмийн эрүүл мэнд.....	8
2.2.3 Монголын уламжлалт анагаах ухаан.....	8
2.3 БИЗНЕС, ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ.....	8
ГУРАВ. ӨМЧТЭЙ МОНГОЛ ХҮН	9
3.1 ЭРХ ЧӨЛӨӨТЭЙ МОНГОЛ ХҮН.....	9
3.2 ӨМЧТЭЙ МОНГОЛ ХҮН.....	9
3.3 ХАРИУЦЛАГАТАЙ МОНГОЛ ХҮН.....	9
3.4 АЮУЛГҮЙ ОРЧИНТОЙ МОНГОЛ ХҮН.....	9
ДӨРӨВ. БҮТЭЭЛЧ МОНГОЛ	9
4.1 АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАР.....	9

4.2	УУЛ УУРХАЙН САЛБАР.....	10
4.3	БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН САЛБАР	10
4.4	ТЭЭВРИЙН САЛБАР.....	10
4.5	ХООЛ, ХҮНС ҮЙЛДВЭРЛЭЛИЙН САЛБАР	10
4.6	САНХҮҮГИЙН САЛБАР	10
4.7	НИЙГЭМ ХАМГААЛЛЫН САЛБАР	10
4.8	СОЁЛ, УРЛАГИЙН САЛБАР	11
4.9	АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЛБАР	11
ТАВ. ӨРИЙН ДАРАМТГҮЙ МОНГОЛ.....		11
5.1	ТӨСВИЙН ШИНЭЧЛЭЛ.....	11
5.3	БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТ, ГАЗРЫН ХАРИЛЦАА.....	11
5.4	ХҮНСНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ.....	12
5.5	ДЭД БҮТЦИЙН ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	12
5.5.1	Ус.....	12
5.5.2	Авто зам.....	12
5.5.3	Эрчим хүч.....	12
5.5.4	Хөдөө аж ахуй.....	12
ЗУРГАА. ТӨРИЙН ДАРАМТГҮЙ МОНГОЛ.....		13
6.1	ОРОН НУТГИЙН ХӨГЖИЛ.....	13
ДОЛОО. ИРГЭНДЭЭ ЭЭЛТЭЙ МОНГОЛ.....		13
7.1	ИРГЭНДЭЭ ЭЭЛТЭЙ ТӨРИЙН БОДЛОГО.....	13
7.2	ЧАДВАРЛАГ ТӨРИЙН АЛБА.....	13
7.3	ЦАХИМ ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ.....	14
НАЙМ. ШУДАРГА МОНГОЛ.....		14
8.1	ХУУЛЬ БА ШУДАРГА ЁС.....	14
8.1.1	Иргэний шударга ёс.....	14
8.1.2	Нийтийн шударга ёс.....	14
ЕС. ДЭЛХИЙН МОНГОЛ.....		14
9.1	АМЬД БАЙГАЛЬ.....	14



ӨМНӨТГӨЛ

Монгол Улсын тусгаар тогтнол, Үндэсний эрх ашиг, Үндсэн хуульт ардчиллаа хамгаалан бэхжүүлж, хувь хүний эрх чөлөө, хуулийн засаглал, чөлөөт зах зээл, иргэний нийгмийн зарчимд суурилсан тогтвортой хөгжлийн төлөөх баруун төвийн намын хувьд,

АРДЧИЛСАН НАМ ӨНӨӨГИЙН ЭДИЙН ЗАСАГ, УЛС ТӨРИЙН НӨХЦӨЛ БАЙДЛЫГ ДАРААХ БАЙДЛААР ДҮГНЭЖ БАЙНА:

- Эдийн засаг томорсон гэх ч иргэдийн орлого, худалдан авах чадвар нэмэгдээгүй;
- Валютын нөөц нэмэгдсэн гэх боловч төгрөгийн ханш суларсан;
- Монгол Улсын гадаад өрийг иргэддээ хуваавал хүн бүрт 33.0 сая төгрөг ногдох болсон;
- Туг хийсгэж, тууз хайчлаад томоохон бүтээн байгуулалт ганцыг ч хийгээгүй. Дарханы замыг дуусгаж чадаагүй;
- Цахилгааны доголдол, шатахууны хомсдол тогтмол бий болж, эрчим хүчний асуудал үндэсний аюулгүй байдалд нөлөөлөх болсон;
- Авлигын индексээр 180 улсаас 121 дүгээрт бичигдэж, 2015 оноос хойш 49 байраар ухарсан;
- Монголчуудын 28.8 хувь нь ядуурлын шугамаас доогуур, 21.4 хувь нь ядуурлын шугамд ойр амьдрах болсон. Хүн амын талаас илүү хувь нь ядууралд өртсөн улс болж, дампуурлын ирмэгт тулсан;
- Цар тахлын улмаас боловсролын хоцрогдол газар авч, энэ үзүүлэлтээр мөн л дэлхийд сүүл мушгих болсон;
- Шударга шүүмжлэл хэлсэн хүн бүрийг баривчилж, хорьдог болсон;
- Агаарын бохирдлын улмаас хорт хавдрын шалтгаант нас баралт эрс нэмэгдсэн.

ТИЙМ УЧРААС, 2016-2024 ОНЫГ БИД АЛДАГДСАН 8 ЖИЛ ХЭМЭЭН ДҮГНЭЖ БАЙНА.

Алдагдсан 8 жилийг дүгнэсний үр дүнд алдааг засч, Монгол Улсын эдийн засаг эрчимтэй хөгжсөн, хуулийн засаглал, шударга ёс тогтсон, хүн бүр ажил, хөдөлмөр эрхлэн, орлого нь амьдрал ахуйд хүрэлцсэн, эрүүл, аюулгүй орчинд ажиллаж, амьдарсан хүнлэг, ардчилсан нийгмийг цогцлоохыг **ЭРХЭМ ЗОРИЛГО** болгож,

Сонгуулийн мөрийн хөтөлбөрт санал авах "БҮТЭН АРДЧИЛАЛ" аяныг бүсчилсэн хөгжлийн хэлбэрээр улс, орон даяар зохион байгуулж, аймаг, дүүргийн гишүүд, дэмжигчид, бүх намын хороо, иргэний нийгмийн төлөөлөл, мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллагуудаас авсан саналуудыг иш үндэс болгосон Ардчилсан намын 2024 оны Улсын Их Хурлын ээлжит сонгуульд стратегийн 9 заалт, 9 бүлэг бүхий БҮТЭН МОНГОЛ - БҮРЭН АРДЧИЛАЛ "9+90+900" Эрчимт хөгжлийн төлөвлөгөө, Хэнтий аймгийн Ардчилсан намын "Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчийн Хурлын 2024 оны сонгуульд оролцох мөрийн хөтөлбөрт үндэслэн боловсруулсан

Хэнтий аймгийн сумын Ардчилсан намуудын "Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчийн Хурлын 2024 оны сонгуульд оролцох мөрийн хөтөлбөр"-ийг нэгдмэл байдлаар танилцуулж байна.



НЭГ. БҮТЭН МОНГОЛ

1.1 ХУВИАРАА ХӨДӨЛМӨР ЭРХЛЭГЧИД

1.1.1 “Өрх бүр баялаг бүтээгч” үндэсний хөтөлбөрийг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

1.1.2 Иргэн, аж ахуйн нэгжийн төрөөс авах үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлнэ.

1.2 ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРТ АЖИЛЛАГСАД: МАЛЧИД, ТАРИАЛАНЧИД БОЛОН БУСАД

1.2.1 Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэрлэлийг хөгжүүлж, иргэдийн бодит орлогыг нэмэгдүүлнэ.

1.2.2 Малчин өрх нь хүчин чадал өндөртэй техник, тоног төхөөрөмж ашиглах нөхцөлийг бүрдүүлнэ.

1.2.3 Малчдын хамтын оролцоонд тулгуурлан бэлчээр нутгийн тогтвортой ашиглалтыг хангаж, доройтсон бэлчээрийн 30-аас доошгүй хувийг сэргээнэ.

1.2.4 Хөдөөгийн малчин өрхийг дэмжин “Малжуулах хөтөлбөр”-ийг бүх сумдад хэрэгжүүлнэ.

1.2.5 Услалтын системийн менежментийг боловсронгуй болгож, тариалан эрхлэгч, хүнсний ногоо тариалагчдыг дэмжинэ.

1.2.6 Мал эмнэлгийн байгууллагын санаачилгад үндэслэн “Малын эмчилгээ, сувилгааны төв”-ийг төв, суурин газруудаас зайтай, бэлчээрийн бүс нутагт малчдад ойрхон байгуулах санаачилгыг дэмжинэ.

1.3 ТӨРИЙН АЛБАН ХААГЧИД

1.3.1 Төрийн албанаас эрт тэтгэвэрт гарч буй иргэд жижиг, дунд, бичил бизнесийн салбарт ажиллах, баялаг бүтээх боломжийг бүрдүүлнэ.

1.3.2 Мэргэшсэн нийтийн алба, иргэний оролцоот үнэлгээ, хариуцлагын тогтолцоо бүхий нийтийн үйлчилгээг бэхжүүлж, салбарын мэргэшсэн ажилтнуудыг улс төрөөс ангид, тогтвортой ажиллах эрх зүйн баталгааг бүрдүүлнэ.

1.3.3 Бүх шатны төрийн албан хаагчдын эрхэлдэг ажлынхаа чиглэлээр сурч боловсрохыг дэмжиж, жил бүр сургалтад хамруулна.

1.4 СОЁЛ, УРЛАГ, СПОРТЫН САЛБАРЫН АЖИЛЛАГСАД

1.4.1 Сумын соёлын төвүүдэд менежментийн шинэчлэл хийж, бие даасан байдлыг сайжруулна.

1.5 ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮН

1.5.1 Хөгжлийн бэрхшээлтэй хүний асран хамгаалагчдын хөдөлмөр эрхлэлт, өрхийн орлогыг нэмэгдүүлэх санаачлагыг дэмжинэ.

1.5.2 Үйлчилгээний газар, шинээр баригдаж байгаа барилга байгууламж, явган хүний зам, гэрлэн дохиог хөгжлийн бэрхшээлтэй хүн чөлөөтэй зорчих олон улсын стандартын шаардлагад нийцүүлж өөрчилнө.

1.5.3 Хөгжлийн бэрхшээлтэй хүн тогтмол орлого олох боломжийг нэмэгдүүлнэ. (Өрхийн үйлдвэрлэл, бүтээгдэхүүний нийтлэг шаардлага, борлуулалтын сүлжээ)

1.6 СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН НАСНЫ ХҮҮХДҮҮД

1.6.1 Цэцэрлэг, сургуулийн нэг ангийн хүүхдийн тоог 25-аас хэтрүүлэхгүй байх стандарт хэрэгжүүлнэ.

1.6.2 Өрх, суманд үзүүлэх 0-5 насны хүүхдийн тусламж үйлчилгээг чанаржуулах, хүртээмжийг сайжруулах, хөхөөр хооллолтыг дэмжих “Эрүүл чийрэг хүүхэд” хөтөлбөр хэрэгжүүлнэ.

1.7 ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН СУРАГЧИД

1.7.1 Хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх “Боловсролын цөм” хөтөлбөрийн хүрээнд төр, орон нутаг, иргэний нийгмийн байгууллага, гэр бүлийн оролцоог өргөжүүлнэ.

1.7.2 Дотуур байрны орчин, нөхцөлийг сайжруулах төсөл хэрэгжүүлнэ.

1.7.3 Хүүхдэд тулгарч буй дээрэлхэх, үе тэнгийнхэний дарамт, шахалт болон эрүүл мэнд, сэтгэцийн бусад сорилт, бэрхшээлтэй холбоотой асуудлуудыг шийдвэрлэхэд чиглэсэн төсөл хэрэгжүүлнэ.

1.8 ОЮУТАН, ЗАЛУУЧУУД

1.8.1 Иргэд ажиллангаа суралцах, суралцангаа хөдөлмөр эрхлэх боломжийг дэмжин, залуучуудыг өөрөө өөртөө ажлын байр бий болгох, бизнес эрхлэх боломжийг бүрдүүлнэ.

1.8.2 Орон нутагт ажиллаж буй залуучуудыг дэмжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлнэ.

1.9 ЗАЛУУ ГЭР БҮЛ ба ӨРХ ТОЛГОЙЛСОН ЭЦЭГ, ЭХ

1.9.1 Ажил, хөдөлмөр эрхлэх, санхүү, бизнесээ өргөжүүлэх, амьдрах орчноо хамтдаа сайжруулах мэдлэг, ур чадварын сургалт, зөвлөмжөөр хангагдах боломжийг орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулан хэрэгжүүлнэ.

1.9.2 Хүүхдийн хүмүүжил, төлөвшлийн асуудалд онцгой анхаарч, цэцэрлэгийн өмнөх насны хүүхдийг гэр бүлийнхээ орчинд эцэг, эхтэйгээ хамт хүмүүжин төлөвших нөхцлийг бүрдүүлнэ.

1.9.3 Хүүхдийг эрсдэлээс хамгаалах зорилгоор өрх толгойлсон эх эсвэл эцгийн богиносгосон ажлын цагийн хуваарийг мөрдөх боломж бүрдүүлнэ.

1.10 АХМАДУУД

1.10.1 Ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих замаар алслагдсан бүс нутагт дутагдалтай мэргэжилтнүүдийг бүрдүүлэх “Ахмад мэргэжилтний алба” ажиллуулах санаачилга, хөдөлгөөн өрнүүлнэ.

1.10.2 Ахмадын сургалтын нэгжтэй болж, дахин ур чадваржуулах төсөл, арга хэмжээг хэрэгжүүлнэ.

1.10.3 Ахмадын эрүүл мэндийн тогтолцоог сайжруулна.

1.11 ГАДААДАД СУРЧ, АЖИЛЛАЖ, АМЬДАРЧ БАЙГАА ИРГЭД

1.11.1 Гадаадад ажиллаж байгаа иргэдийн мэргэшсэн байдлыг харгалзан өөрийн туршлага, шинэ мэдлэг шингэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээг сумандаа нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

1.12 ОРОН СУУЦ, ГЭР ХОРООЛОЛД АМЬДАРДАГ ИРГЭД

1.12.1 Иргэд өөрийн өмчилж авсан хашааны газар дээр айл, хөрш, гудамжаараа нэгдэн төлөвлөлт хийж, сэргээгдэх эрчим хүч, цэвэр бохир усны бичил бүтэц бий болох хоршин амьдрах иргэдийн санаачлагыг дэмжинэ.

1.12.2 Орчноо ногооруулсан иргэд, аж ахуйн нэгжийг дэмжсэн хөтөлбөр хэрэгжүүлнэ.

1.13 АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЛБАРТ АЖИЛЛАГСАД

1.13.1 Орон нутгийн иргэдийн амьдралд эергээр нөлөөлөх, жуулчдад чанартай үйлчилгээ үзүүлэх аялал жуулчлалын дэд бүтцэд хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.

ХОЁР. СЭРСЭН МОНГОЛ

2.1 ЦОГЦ БОЛОВСРОЛ

2.1.1 Боловсролын их шилжилт ба хүртээмж

2.1.1.1 Нийгмийн хариуцлагын хүрээнд “Хүүхэд бүрт компьютер” хөтөлбөр хэрэгжүүлэх санал, санаачилгыг дэмжинэ.

2.1.1.2 Бүх шатны боловсролын байгууллага, багш болон суралцагчдын үнэлгээг бодит болгож, эцэг, эх, асран хамгаалагчид хүүхдийнхээ сурлагын чанарт хяналт тавих

2.1.1.3 Ерөнхий боловсролын сургалтын гол зорилго нь эх оронч монгол хүнийг бэлтгэх явдал хэмээн үзэж, монгол хэл, уран зохиол, түүхийн хичээлийг цагийг нэмж чанаржуулна.

2.1.1.4 Боловсролын салбарын өрсөлдөх чадварыг дээшлүүлж, одоо байгаа аймгийн дундаж түвшинд хүргэнэ.

2.1.1.5 Амьдрах чадварын чухалчилан сургуулиудын материаллаг бааз, сургалтын техник тоног төхөөрөмжийг шинэчлэх төслийг дэмжинэ.

2.1.2 Сургуулийн өмнөх боловсрол

2.1.2.1 Бага насны хүүхдийн хөгжлийн хоцрогдол, хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэн оношлож, хүүхэд бүрт тохирох шаардлагатай сэргээн засах үйлчилгээнд хамруулна.

2.1.2.2 Хүүхэд бүрийг хөгжүүлж, бүтээлч сэтгэлгээтэй, өөртөө итгэлтэй, байгаль орчин, үндэсний хэл, соёл, уламжлалаар бахархдаг хүмүүжил олгох арга хэмжээнүүдийг чанаржуулан үргэлжлүүлнэ.

2.1.2.3 Сургууль, цэцэрлэгийн удирдлагыг мэргэшсэн, тогтвортой, улс төрөөс хараат бус байх нөхцөлийг бүрдүүлж, тэднийг чөлөөлөх, томилох асуудалд сумын иргэдийн төлөөллөөс бүрдсэн “боловсролын зөвлөл”-ийн саналыг харгалздаг болно.

2.1.3 Бага, дунд боловсрол

2.1.3.1 Малчин өрхийн бага ангийн хүүхдийг багийн бага сургууль болон гэрээр хослон сургах “гэрт ойр” тогтолцоог бүрдүүлнэ.

2.1.3.2 Хичээлээс гадуурх сургалт, дугуйлангийн хамрагдалтыг 70%-д хүргэж, суралцагчийн сонирхол, чадварыг нээн хөгжүүлэх сонгон, секц, дугуйлангийн үйл ажиллагааг өргөтгөнө.

2.1.3.3 Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын сурлагын хоцрогдлыг 50%-иар бууруулна.

2.1.4 Багшийн мэргэжлийн хөгжил

2.1.4.1 Багшийн үндсэн ажил буюу суралцах үйл ажиллагааг нэмэгдүүлж, шаардлагагүй бусад ажлыг эрс багасган, багшийн уян хатан цагаар ажиллах боломжийг нэмэгдүүлнэ.

2.1.4.2 Багшийн нэр хүнд, аюулгүй ажиллах орчныг баталгаажуулан, сургууль, цэцэрлэгийн удирдах ажилтныг тусгайлан бэлтгэнэ.

2.1.4.3 Багш нарын мэдлэг, ур чадварыг тухай бүрд нь дээшлүүлж “Шинэ багш” хөтөлбөр хэрэгжүүлнэ.

2.1.4.4 Багш, суралцагчдын хөгжлийг дэмжих сургалтын цахим лаборатори, видео хичээл, е-сурах бичиг, онлайн сургалт, виртуал орчин бүхий сургалтын нээлттэй тогтолцоог дэмжинэ.

2.2 ЭРҮҮЛ МЭНД – ЭРХЭМ БАЯЛАГ

2.2.1 Нийгмийн эрүүл мэнд

2.2.1.1 Сэргийлж болох болон амьдралын буруу хэвшлээс үүдэлтэй өвчлөл, нас баралтыг хувийг бууруулж, урьдчилан сэргийлнэ.

2.2.1.2 Хуурамч, чанаргүй хүнсний бүтээгдэхүүний хяналтын тогтолцоог сайжруулахад иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ.

2.2.1.3 Бүх нийтийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж, эрүүл аж төрөх дадлыг хэвшүүлнэ.

2.2.1.4 Нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх арга хэмжээнүүдийг санаачлан хэрэгжүүлнэ.

2.2.2 Эмнэлгийн тусламж, үйлчилгээ

2.2.2.1 Явуулын эмнэлгийн тоог нэмэгдүүлж чанаржуулахад анхаарч, багийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна.

2.2.2.2 Өрх, сумын эрүүл мэндийн төвд ажиллах эмчийн ажиллаж, амьдрах орчинг сайжруулж, тоог нэмэгдүүлнэ.

2.2.3 Монголын уламжлалт анагаах ухаан

2.2.3.1 Анхан шатны эрүүл мэнд болон нийтийн эрүүл мэндийн төвийн үйлчилгээнд уламжлалт анагаах ухааны эзлэх хувийг нэмэгдүүлнэ.

2.3 БИЗНЕС, ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

2.3.1 Хөдөлмөрийн нөөцийн үр ашигтай удирдлагыг хэрэгжүүлж, эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэх зорилгоор “Үндэсний бүтээмжийн хөтөлбөр” хэрэгжүүлнэ.

2.3.2 Цагаар ажиллах, гэрээр ажиллах, зайнаас ажиллуулах, сүлжээний маркетинг бүхий бараа, үйлчилгээний борлуулалт хийх зэрэг хөдөлмөр эрхлэлтийн олон хэлбэрийг дэмжих замаар эмэгтэйчүүд, оюутан, залуучууд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ.

ГУРАВ. ӨМЧТЭЙ МОНГОЛ ХҮН

3.1 ЭРХ ЧӨЛӨӨТЭЙ МОНГОЛ ХҮН

3.1.1 Хүний заяагдмал эрхийг хамгаалж, иргэдэд хүний эрхийн талаар ойлголтыг өгөх, сурталчлан таниулах үйл ажиллагааг дэмжинэ.

3.1.3 Олон нийтийн сүлжээнд иргэний үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөнд хязгаарлалт тогтоохгүй байхыг дэмжинэ.

3.2 ӨМЧТЭЙ МОНГОЛ ХҮН

3.2.1 Газар эзэмших, ашиглах, өмчлөхтэй холбоотой харилцааг зохицуулсан хууль, журмын хэрэгжилтийг шудрага, ил тод болгоно.

3.2.2 Хувь хүн, өрх гэр баялаг бүтээх талбарт хамтран ажиллагсдын ашиг сонирхлын нийтлэг харилцаанд төрийн оролцоо, дарамт, шахалтыг хязгаарлана.

3.2.3 Өмчийн эрхийг баталгаажуулах, хувийн өмчийг хамгаалахад чиглэсэн шаардлагатай бүхий л арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

3.3 ХАРИУЦЛАГАТАЙ МОНГОЛ ХҮН

3.3.1 “Хариуцлагатай монгол хүн” хөгжлийн хөтөлбөр гаргах бөгөөд хөтөлбөрт дараах хариуцлагын үзүүлэлтүүдийг тусган хэрэгжүүлнэ:

- Нийгэм, улс төрийн үйл ажиллагаанд тухайлбал улс төрийн сонгуульд идэвхтэй оролцох, нийгмийн сайн сайхны төлөө ажиллах;
- Байгаль орчиндоо ээлтэй хандах, жам ёсоор нь хадгалах, сэргээх, хөгжүүлэхэд хувь нэмэрээ оруулагч, байгалийн нөөц ялангуяа цэвэр усны нөөцдөө ариг гамтай хандагч байх;
- Олон талын мэдээлэлд дүн шинжилгээ хийж чаддаг, бодит мэдээлэл, баримт нотолгоонд тулгуурласан дүгнэлт гаргадаг чадвартай байх;
- Ардчилал, улс төр, засаглалын хөгжил, түүхийн мэдлэгээр өөрийгөө үргэлж цэнэглэн баяжуулагч, насан туршдаа боловсрогч, иргэний боловсролоор өөрийгөө хөгжүүлэгч байх;
- Ардчиллын үйл ажиллагаанд идэвхтэй оролцогч байна. Бүх шатны сонгуульд саналаа өгөх, Улсын Их Хуралд сонгогдсон гишүүн, иргэдийн төлөөлөгчдийн хуралд сонгогдсон төлөөлөгчтэй холбогдон, санал сэтгэгдлээ илэрхийлдэг байх.

3.4 АЮУЛГҮЙ ОРЧИНТОЙ МОНГОЛ ХҮН

3.4.1 Гамшиг, аюулаас хамгаалах үндэсний бүтэц бий болгож, үйл ажиллагааг мэргэжлийн байгууллагын болон орон нутгийн иргэдийн хамтын тогтолцоотой болгоно.

3.4.4 Нийтийн эзэмшлийн зам, талбай дахь камержуулалтын ажлыг журам, эрх зүйн хүрээнд зохион байгуулна.

ДӨРӨВ. БҮТЭЭЛЧ МОНГОЛ

4.1 АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАР

4.1.1 Шинээр бизнес эрхэлж буй иргэдийг хууль, эрх зүйн хүрээнд дэмжинэ.

4.1.2 Хоршоог дэмжих сангийн эх үүсвэрийг нэмэгдүүлж, нутгийн брендийн үйлдвэрлэлийг дэмжин, борлуулалтын нэгдмэл тогтолцоотой болно.

4.1.3 Нутгийн бренд үйлдвэрлэгчдийг төвлөрсөн суурин газарт борлуулалт хийх, бүтээгдэхүүнээ олон нийтэд таниулан сурталчилахад нь дэмжлэг үзүүлнэ.

4.2 УУЛ УУРХАЙН САЛБАР

4.2.1 Бичил уурхайн шаардлага хангасан зарим нөхөрлөл, хоршоог уул уурхайн олборлолтын аж ахуйн нэгж хэлбэрээр албажуулан хууль бус олборлогчдод тавих төрийн хяналтын тогтолцоог сайжруулна.

4.2.2 Хариуцлагатай уул уурхайн зарчмын дагуу нөхөн сэргээлт, хаалтын асуудлыг тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж бүрэн хариуцан гүйцэтгэдэг болгоно.

4.2.3 Байгалийн баялгаас орж буй орлого, төсөв, тендерийг иргэдээр хэлэлцүүлдэг тогтолцоог шинэ шатанд гаргана.

4.3 БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН САЛБАР

4.4.1 Эрдэс баялгийн болон малын гаралтай түүхий эд боловсруулах, бүтээгдэхүүн үйлдвэрлэх, жижиг үйлдвэрлэлийг хөгжүүлж, ажлын байр бий болгоно.

4.4.2 Малаас гарч буй түүхий эд, арьс шир, ноос ноолуур боловсруулах үйлдвэрлэлийн сум дундын төвүүдийг түүхий эд бэлтгэх нэгдмэл сүлжээтэй болно.

4.4 ТЭЭВРИЙН САЛБАР

4.4.1 Хот хоорондын зорчигч тээврийн үйлчилгээг чөлөөт өрсөлдөөнд шилжүүлж, дагаж мөрдөх стандартыг сайжруулна.

4.5 ХООЛ, ХҮНС ҮЙЛДВЭРЛЭЛИЙН САЛБАР

4.5.1 Хүнсний худалдаанд баримталдаг ариун цэвэр, аюулгүй байдлын стандартыг чанд мөрдүүлнэ.

4.5.2 Хүн амыг эрүүл, аюулгүй хүнсээр хангахад чиглэгдсэн хүнсний стандартыг чанд мөрдүүлнэ.

4.5.3 Жимс, жимсгэнэ, нарийн ногоо тариалах болон хүлэмжийн газар олгох, ашиглахад уян хатан хандаж, гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг дэмжинэ.

4.6 САНХҮҮГИЙН САЛБАР

4.6.1 Засаглалыг сайжруулах, нягтлан бодох бүртгэл, дотоод аудитын чанар, хяналт, шалгалтын үр дүнтэй арга хэлбэрийг хэрэгжүүлэх ажлыг шинэ шатанд гаргана.

4.7 НИЙГЭМ ХАМГААЛЛЫН САЛБАР

4.7.1 “Хүүхдийн мөнгө” хөтөлбөрийг үргэлжлүүлнэ.

4.7.2 Халамжийг нэмэгдүүлэх бус, ажил хөдөлмөр, бизнес эрхлэгч нарыг дэмжсэн хөтөлбөр боловсруулан ажиллана.

4.7.3 Нийтийг хамарсан гамшигт өртөгчдөд үзүүлэх халамжийн тусламж, үйлчилгээг бий болгоно.

4.7.4 Нийгмийн халамжийг зорилтот бүлэгт чиглүүлэн, тэдний хөдөлмөр эрхлэх сэдлийг бий болгох, шаардлагатай тохиолдолд хөдөлмөр эрхлэлтэд шилжүүлэх, өрх, иргэнийг ядуурлаас гарахад дэмжлэг үзүүлнэ.

4.7.5 Ядуурлыг бууруулах хөтөлбөрийг баг, сумын түвшинд тодорхой зорилт, шалгуур үзүүлэлтээр гаргаж, холбогдох байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулна.

4.7.6 Бага орлоготой, ядуу айл өрхүүдийн хүнсний хангамжийг сайжруулах, шим тэжээлийн дутагдлаас хамгаалах ажлыг тэгш, хүртээмжтэй зохион байгуулна

4.8 СОЁЛ, УРЛАГИЙН САЛБАР

4.8.1 Биет бус соёлын өвийг бүртгэж, хадгалах зорилгоор дүрс бичлэг бүхий дижитал архив үүсгэнэ.

4.8.2 Түүх, соёлын дурсгалт газруудын виртуал бодит аяллыг хөгжүүлнэ.

4.8.3 Хувь хүний эрх чөлөө, ардчилал, чөлөөт эдийн засгийн ач холбогдлыг таниулах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлнэ.

4.8.4 Археологийн болон түүх, соёлын дурсгалт газрын хамгаалалтыг сайжруулж, соёлын өвийг хамгаалагч, харгалзагчтай болгож, эдийн засгийн эргэлтэд оруулна.

4.9 АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЛБАР

4.9.1 “Шүршүүр - жорлон” хөтөлбөрийг тухайн бүс нутагт үйл ажиллагаа явуулж байгаа шатахуун түгээх станц болон өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүний дэлгүүрүүдэд санал болгож, хамтран хэрэгжүүлнэ.

4.9.2 Жуулчдад чанартай үйлчилгээ үзүүлэх аялал жуулчлалын дэд бүтцэд хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг дэмжинэ.

4.9.3 Спорт, эрүүл мэнд, явган алхалт, эко туризм зэрэг нүүдэлчний өв соёлыг сурталчлах аялал жуулчлалын төрөл хэлбэрүүдийг дэмжинэ.

4.9.4 Өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр гаргасан санал санаачилгыг дэмжинэ.

ТАВ. ӨРИЙН ДАРАМТГҮЙ МОНГОЛ

5.1 ТӨСВИЙН ШИНЭЧЛЭЛ

5.1.1 Орон нутгийн төсвийн зарлагыг 20 хувиар бууруулна.

5.1.2 Орон нутгийн төсвийн зардлыг ач холбогдлоор нь эрэмбэлж, үр ашигтай хуваарилалтын зарчмыг хэрэгжүүлнэ.

5.1.3 Татвар төлөгчийн суурийг өргөжүүлэх замаар орон нутгийн төсвийн орлогыг тогтвортой өсгөх нөхцөлийг бүрдүүлнэ.

5.1.4 Ажлын байр шинээр бий болгох хувийн хэвшлийн санал, санаачилгыг дэмжиж, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлнэ.

5.2 АЖ ҮЙЛДВЭРИЙН ХӨГЖИЛ, БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРҮҮД

5.2.1 Үйлдвэрлэл хөгжүүлэх тэргүүлэх чиглэлийг сум дундын хэлбэрээр тодорхойлно.

5.2.2 Стандартын шаардлага хангасан бүх төрлийн металл, хуванцар, резинийг дахин боловсруулах, бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйлдвэрийг хөнгөлттэй зээлийн бодлогоор дэмжинэ.

5.2.3 Малын тэжээл, бордооны үйлдвэрийг барьж, ашиглалтад оруулна.

5.3 БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТ, ГАЗРЫН ХАРИЛЦАА

5.3.1 Хүн амыг орон сууцжуулах зорилтын хүрээнд дараах чиглэлээр орон сууцны бодлого хэрэгжүүлнэ. Үүнд:

- “Тогтвортой орлого бүхий орон сууц” хөтөлбөрийг хэрэгжүүлж, сумын төвүүдэд 10 айлын орон сууцыг бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн



байршилтай уялдуулан хүн амын зорилтот бүлэгт тааламжтай нөхцөлөөр бүтээн байгуулах хувийн хэвшлийн санал, санаачилгыг дэмжинэ.

- Хашаандаа амины тохилог орон сууц барих санаачилгыг дэмжинэ. (сум бүрт 20 хүртэл)

5.3.2 Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд ажиллаж амьдрах таатай нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор сумдын ерөнхий төлөвлөгөө, зураг төслийн шинэчлэлд иргэдийн оролцоог нэмэгдүүлж, дэд бүтэцжүүлэх ажлыг хэрэгжүүлнэ.

5.4 ХҮНСНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ

5.4.1 Хүн амын хүнсний гол нэр төрлийн бүтээгдэхүүний дотоодын хэрэгцээг аюулгүй, чанартай хүнсээр хүртээмжтэй, тогтвортой хангах нөхцөлийг бүрдүүлнэ.

5.4.2 Байгалийн болон бэлчээрийн мал аж ахуйн гаралтай органик хүнс, хүнсний нэмэлт тэжээлийн үйлдвэрлэлийг дэмжиж, экспортын хэмжээг нэмэгдүүлнэ.

5.4.3 Хүнс, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний худалдааны орчныг либералчилж, эко, ногоон, органик шошготой бүтээгдэхүүнийг олшруулан сав баглаа, боодлыг улсын нэгдмэл стандартыг мөрдөнө.

5.5 ДЭД БҮТЦИЙН ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

5.5.1 Ус

5.5.1.1 Гадаргын усгүй бэлчээр нутагт усан сан байгуулж, усны нөөцийг нэмэгдүүлэх төслүүдийг дэмжинэ.

5.5.1.2 “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн болон цөлжилттэй тэмцэх ажлын хүрээнд сум бүрт 50-100 га ногоон байгууламж бий болгоно.

5.5.2 Авто зам

5.5.2.1 Сумын төвийн авто замын сүлжээний хүрээнд нийт 2 км хүртэл хайрган ба хатуу хучилттай авто замыг шинээр барина.

5.5.2.2 Сумын төв доторх авто замын нэгдсэн стандарт мөрдөж, шинээр баригдах авто замын чанарын хяналтыг сайжруулна.

5.5.3 Эрчим хүч

5.5.3.1 Айл өрхийг хосолмол цахилгаан эрчим хүчний эх үүсвэртэй болж, илүүдэл эрчим хүчийг сүлжээнд нийлүүлдэг “өрх бүр эрчим хүч үйлдвэрлэгч” болох санаачлагыг дэмжинэ.

5.5.4 Хөдөө аж ахуй

5.5.4.1 “Хариуцлагатай, чинээлэг малчин” хөтөлбөр хэрэгжүүлнэ.

5.5.4.2 Мал, малын гаралтай бүх төрлийн түүхий эд, бүтээгдэхүүний үнэ цэнийг нэмэгдүүлж, эдийн засгийн эргэлтийг хурдасгах замаар малчдын амьжиргаа, орлогыг дээшлүүлэх нөхцөл бүрдүүлнэ.

5.5.4.3 Малын тэжээлээ бэлтгэхэд чиглэсэн өвөлжөө, хаваржаандаа тэжээлийн тариалалтын талбайтай болох санаачлагыг дэмжинэ.

5.5.4.4 Малын гаралтай хоёр дахь түүхий эдийг хаягдалгүй боловсруулах өндөр уургийн агууламжтай түүхий эд үйлдвэрлэх чиглэлд хөрөнгө оруулалтыг дэмжинэ.

5.5.4.5 Гахай, махны болон өндөгний тахианы хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг дэмжиж, орон нутгийн өндөгний хангамж, гахай, тахианы махны хангамж нэмэгдүүлнэ.

5.5.4.6 Сумын мал эмнэлгийн үйлчилгээний чадавхийг сайжруулан малыг эрүүлжүүлэх ажил, махны гарал үүслийн гэрчилгээ, баталгаажуулалтын түвшинг сайжруулна.

5.5.4.7 Эрсдэл бүхий нөхцөлөөс урьдчилан сэргийлэх тохиолдол бий болсон үед малчдад худалдан борлуулж, эргэлтэд оруулах зорилготой өвс, тэжээлийн нөөцийн фондын сум дундын тогтолцоог бий болгоно.

ЗУРГАА. ТӨРИЙН ДАРАМТГҮЙ МОНГОЛ

6.1 ОРОН НУТГИЙН ХӨГЖИЛ

6.1.1 Сумын төвийн үерийн далан суваг, борооны болон хөрсний ус зайлуулах шугам сүлжээний ажлыг хийж хэрэгжүүлнэ.

6.1.2 “Сумын хөгжил: Инженерийн дэд бүтцийн хангамж” төсөл арга хэмжээг үргэлжлүүлж, бүх сумдыг хамруулах ажлыг үе шаттай эхлүүлнэ.

6.1.3 Сумдын цахилгаан эрчим хүчний дэд станцуудыг өргөтгөх, цахилгаан дамжуулах агаарын шугамуудын насжилтыг тодорхойлж, өргөтгөн шинэчилнэ.

6.1.4 Улсын чанартай хатуу хучилттай авто зам, орон нутгийн замын байгууламжийн дагуу олон улсын стандартад нийцсэн авто үйлчилгээний түр буудаллах цогцолбор байгуулна.

6.1.5 Мах хөргөлтийн агуулах зоорь сумдад малын түүхий эд боловсруулах үйлдвэр байгуулна.

6.1.6 Байгалийн үзэсгэлэнт, түүхэн дурсгалт газруудыг түшиглэн аялал жуулчлалын цахимжсан, хүртээмжтэй, найдвартай үйлчилгээг нэвтрүүлнэ. (Батширээт, Биндэр, Баян-Адрага, Дадал сум, Хөх нуур, Аварга тосон, Гүрэмийн нуур орчмын амралтын газар, гэр буудал, хоолны газрын мэдээллийн сүлжээ)

ДОЛОО. ИРГЭНДЭЭ ЭЭЛТЭЙ МОНГОЛ

7.1 ИРГЭНДЭЭ ЭЭЛТЭЙ ТӨРИЙН БОДЛОГО

7.1.1 Иргэдийн бодитой, үнэн зөв, тэнцвэртэй мэдээлэл авах, үзэл бодлоо илэрхийлэх эрхийг ханган ажиллана.

7.1.2 Төрийн тендер, худалдан авах ажиллагаанд иргэд хяналт тавих боломжийг бүрдүүлж, ил тод, нээлттэй байна.


7.1.3 Хүн амыг эрүүл, аюулгүй хүнсээр хангах стандарт, шалгуур, дүрэм, журмыг мөрдөж, импортын хүнсний чанарт тавих хяналт, шалгалтыг тогтмолжуулна.

7.1.4 Хууль сурталчлах, таниулах ажлын чанарыг дээшлүүлж, олон нийтэд хууль зүйн мэдээллийг шуурхай, үр дүнтэй хүргэх үйлчилгээг бий болгоно.

7.1.5 Хүн амын хүнсний аюулгүй байдлын бие даасан байдлыг хангах зорилтыг хэрэгжүүлж, монгол хүнд эрүүл хоол, хүнс хэрэглэх дадлыг төлөвшүүлэн эрүүл, шимт тэжээллэг хоол, хүнсний хангамж, хүртээмжийг нэмэгдүүлнэ.

7.2 ЧАДВАРЛАГ ТӨРИЙН АЛБА

7.2.1 Төрийн үйлчилгээнд хувийн хэвшил, иргэний оролцоот үнэлгээ, хариуцлагын тогтолцоог нэвтрүүлнэ.



7.2.2 Орон нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагааны давхардлыг арилгах, нэгтгэх замаар бүтэц, зохион байгуулалтыг оновчтой, цомхон болгоно.

7.2.3 Төрийн байгууллага, удирдах албан тушаалтан жил бүр ажлын тайлангийн сонсголоо иргэдэд нээлттэй, ил тод хийх ажлыг тогтмолжуулна.

7.2.4 Төрийн албаны мерит зарчмыг хадгална.

7.3 ЦАХИМ ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

7.3.1 Иргэд, аж ахуйн нэгжийн төрөөс авах үйлчилгээг бүрэн цахим хэлбэрт шилжүүлнэ.

7.3.2 Төрийн байгууллагад байгаа мэдээллийг иргэн, аж ахуйн нэгжээс шаарддаг байдлыг бүрэн халж, иргэд нэг удаа бүртгүүлээд төрийн цахим үйлчилгээг шуурхай авдаг болно.

НАЙМ. ШУДАРГА МОНГОЛ

8.1 ХУУЛЬ БА ШУДАРГА ЁС

8.1.1 Иргэний шударга ёс

8.1.1.1 Төрийн үйл ажиллагаа, төсвийн зарцуулалт, төрийн өмчит аж ахуйн нэгжүүдэд тавих иргэний болон хөндлөнгийн хяналтыг нэмэгдүүлнэ.

8.1.1.2 Иргэдийн өргөдөл, гомдлыг хууль зүйн үндэслэлгүй хүлээн авахаас татгалзах, шийдвэрлэхгүй хугацаа хэтрүүлсэн төрийн албан тушаалтанд тодорхой хариуцлага хүлээлгэдэг болгоно.

8.1.2 Нийтийн шударга ёс

8.1.2.1 Авлига, албан тушаалын гэмт хэрэг, хууль бус шийдвэрийн улмаас учирсан хохирлыг барагдуулах механизмыг сайжруулна.

8.1.2.2 Газрын төлөвлөлт, олголтын орчинд реформ хийж, газар олгох, ашиглах, эзэмших, өмчлөх үйл ажиллагааг ил тод болгоно.

ЕС. ДЭЛХИЙН МОНГОЛ

9.1 АМЬД БАЙГАЛЬ

9.1.1 Усны нөөцийн хомсдолоос сэргийлж, гадаргын усыг хуримтлуулан хэрэгцээг хүртээмжтэй хангах нөхцөлийг бүрдүүлнэ.

9.1.2 Сум, багийн төвийн ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдүүлж газар чөлөөлөх, усны нөөц бохирдох, хомсдохоос сэргийлэх ажлыг сайжруулна.

9.1.3 Ус хангамжийн эх үүсвэрийн барилга байгууламжийг өргөтгөх, шаардлага хангасан ундны усаар хангагдсан хүн амын тоог нэмэгдүүлнэ.

9.1.4 Хог хаягдлыг бууруулах, эдийн засгийн эргэлтэд оруулахад чиглэсэн эко төлбөрийг бий болгоно.

9.1.5 Эвдрэл, доройтолд орсон газрыг нөхөн сэргээх ашиглагчийн хариуцлагыг өндөржүүлж, аж ахуйн зориулалтаар дахин ашиглах боломжтой болгон эргэлтэд оруулна.

9.1.6 Газар зохион байгуулалтын төлөвлөгөө, байгаль орчны менежментийн төлөвлөгөөгөөр дамжуулан газрыг зохистой ашиглах, нөхөн сэргээнэ.

2317144297
СЮА0046 9074082

9.1.7 Хог хаягдлын төвлөрсөн цэгийн стандартын ландфиллын байгууламж, аюултай хог хаягдлыг түр хадгалах, устгах зориулалтын байгууламжийг үе шаттайгаар байгуулна.

9.1.8 Ойжуулах, ойг цэвэрлэх, нөхөн сэргээх асуудлыг цогцоор нь шийдвэрлэж, шинэ арга аргачлал, технологи нэвтрүүлнэ. (Цэнхэрмандал, Өмнөдэлгэр, Батширээт, Биндэр, Баян-Адрага, Дадал, Норовлин)

9.1.9 Ойг нөхөн сэргээх, ойжуулах, байгалийн сэргэн ургалтыг дэмжих, ойн хамгаалалалтын зурвас байгуулах арга хэмжээг нэмэгдүүлнэ. (Цэнхэрмандал, Өмнөдэлгэр, Батширээт, Биндэр, Баян-Адрага, Дадал, Норовлин)

9.1.10 Эко системийн тэнцвэрт байдлыг хадгалах, ой, рашаан, булагийг хамгаалах чиглэлээр өөрийн хөрөнгөөр нөхөн сэргээсэн иргэн, аж ахуйн нэгжид төрөөс урамшуулал олгох эрх зүйн орчныг бүрдүүлнэ.

9.1.11 Иргэдийн хашаа, гудамж, хаваржаа, өвөлжөөндөө мод тарих санаачилгыг дэмжиж, бүртгэлийг цахимжуулна.

9.1.12 Гадаргын усгүй нутагт үерийн усыг тогтоон барих далан, шингээх худаг, нэвчүүлэх хөв, цөөрөм байгуулах замаар усны нөөц баялгийг арвижуулах, нөхөн сэргээх ажлыг дэмжинэ.

